

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/88/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: **З.Мөнгөнцэцэг**

Утас: **9937-2208**

Цахим хаяг: Munguntsetseg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ШИНЭХҮҮ ТАНАА

2021.12.29 № 100
ХТБ-1000/2021-0000



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДСОУС-ын дагуу хийсэн аудитаар бүтдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгсэлтийг эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй бөгөөд материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР



009020102

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	130.6	140.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,186.9	2,081.4
	Нийт хөрөнгийн дүн	2,137.5	2,221.9
	Нийт өр төлбөрийн дүн	3.9	0.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,313.6	2,221.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,317.5	2,221.9
	Үйл ажиллагааны орлогын дүн	705.1	921.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	860.2	1,013.8
	Үйл ажиллагааны үр дүн	(155.1)	(92.1)
	Үйл ажиллагааны бус үр дүн		(0.2)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(155.1)	(92.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,468.7	2,313.6
	Тайлант оны үр дүн	(155.1)	(92.1)
	Эцсийн үлдэгдэл	2,313.6	2,221.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	657.2	802.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	637.0	802.2
	Үйл ажиллагааны ЦМГ	20.2	
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(20.2)	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	803.6	763.0
	Урсгал зардал	803.6	757.6
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	803.6	763.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	800.0	759.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3.6	3.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ЗДТГ нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 62.0 сая төгрөгийн 6 мэдээллийг хоцроож, 13,300.0 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 14,000.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн 1 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 142,555.0 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 479.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,365.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 106,768.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага, 33,942.3 мянган төгрөгийн алдаа зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

- Тус байгууллага нь Монгол Шуудан ХК-тай тооцоо нийлсэн актаар өр төлбөрийн үлдэгдэлгүй боловч лавлагаагаар 448.2 мянган төгрөгийн өрийн үлдэгдэлтэй тул уг өглөгийг бүртгэж, санхүүгийн тайланд залрууллаа.
- Ажилтнаас авах 31.2 мянган төгрөгийн цалингийн авлагыг ерөнхий журналд бүртгэсэн боловч цалин олгох хүснэгтэд уг авлагыг суутгаагүй тул авлагын дансанд залруулав.

Төлбөрийн акт

- Сумын Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/98 дугаар захирамжаар сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Шинэхүүд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 890.8 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон нь улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулсан, тайлант онд сумын төрийн байгууллагуудын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулж, 474.5 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсанд тус тус төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

- Өмнөх оны аудитаар ашиглагдаж байгаа боловч дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй 79,468.0 мянган төгрөгийн барилгыг аймгийн орон нутгийн өмчийн газарт хүсэлт гарган шийдвэрлүүлж, хөрөнгөд бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага хүргүүлээ.

- Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 62.0 сая төгрөгийн 6 мэдээллийг хоцроож, 13,300.0 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 14,000.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн 1 мэдээллийг тус тус байршуулаагүйд мөн албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Байгууллагын 2021 оны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас Аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар Засаг дарга Б.Лхамсүрэнд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,052.2 мянган төгрөгийн мөнгөн шагналыг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 онд баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын ангилалд ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд хамаарна” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаад зөвлөмж өгсөн.

Мөн албан хаагчдад 3,223.3 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1 “нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1. “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байгаад зөвлөмж өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ад	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	142.5	2	0.5	2	1.4	2	106.8	3	33.9
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	9	142.5	2	0.5	2	1.4	2	106.8	3	33.9